



**МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН  
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2023 оны 11 сарын 27 өдөр

Дугаар 44

Улаанбаатар хот

**Аудитын байгууллага сонгох тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.10, 94 дүгээр зүйлийн 94.3, Компанийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.10, Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмын 3 дугаар зүйлийн 3.1.1.в болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг үндэслэн тус тус **ТОГТООХ** нь:

1. Үндэсний аудитын газраас сонгон шалгаруулсан, үнэт цаасны зах зээлд аудитын үйлчилгээ үзүүлэх эрх бүхий “Ихмонгол Хөлөг” ХХК-тай гэрээ байгуулахыг Аудитын хорооны дарга (Н.Улаанхүү)-д даалгасугай.
2. Сонгогдсон аудитын компаниар Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 11 дүгээр зүйлийн 11.16.1, “Санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдийн ажлын гүйцэтгэлийг хянах, үнэлэх, баталгаажуулах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.9.4-д тус тус заасны дагуу санхүүгийн тайлангийн олон улсын стандартын дагуу аудит хийлгэх, мөн олон улсын харилцагч, хөрөнгө оруулагчдад зориулж монгол хэлээс гадна англи хэлээр аудитын зөвлөмж, дүгнэлтийг хийлгүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Х.Алтай)-д үүрэг болгосугай.
3. Олон улсад нэр хүнд бүхий аудитын байгууллагаар компанийн жилийн эцсийн санхүүгийн тайланд дахин аудит хийлгэх шаардлага зүй ёсоор тавигдсан үед тухайн асуудлыг дахин Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж, шийдвэрлүүлэхийг Гүйцэтгэх захирал (Х.Алтай)-д үүрэг болгосугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хорооны дарга (Н.Улаанхүү) -д даалгасугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА**



**Д.ТОГТОХБАЯР**

10117



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 11 сарын 27 өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах  
брокерыг гишүүнээр элсүүлэх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.20, Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн журмын 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 11 дугаар сарын 27-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “БиДиСЕК ҮЦК” ХК-ийг “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гишүүнээр элсүүлсүгэй.
2. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн журмын дагуу “БиДиСЕК ҮЦК” ХК-тай “Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн гэрээ” байгуулахыг Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д даалгасугай.
3. Үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль, тогтоомж, дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж ажиллахыг “БиДиСЕК ҮЦК” ХК /Б.Лхагвадорж/-д үүрэг болгосугай.
4. Хууль тогтоомж болон зах зээлд мөрдөгдөж буй журам, заавар, гишүүнчлэлийн гэрээгээр хүлээсэн гишүүн компанийн үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д үүрэг болгосугай.
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо /Н.Улаанхүү/-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР

172 10118